*Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын*
*даргын 2023 оны 98 дугаар тушаалын*
*8 дугаар хавсралт*

# ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ХЭЛТСИЙН БАЙНГЫН АЖИЛЛАГААТАЙ СУУРИН СТАНЦ, БАЙРЛАЛЫН УЛСЫН СҮЛЖЭЭНИЙ АСУУДАЛ ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН ЛХАМСҮРЭНГИЙН ЗОЛЗАЯАГИЙН 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН, МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС (ГҮЙЦЭТГЭХ АЛБАН ТУШААЛТАН)

Байгууллагын нэр: Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газар
Нэгжийн нэр: Геодези, зураг зүйн хэлтэс

**1. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Арга хэмжээний гүйцэтгэлд өгсөн оноо | Төлөвлөсөн хугацаанд гүйцэтгэсэн байдал | Нийлбэр оноо | Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо |
|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| | Оноо | 60 хүртэл | 10 хүртэл | 70 хүртэл | |
| **Зорилт 1. Монгол Улсын геодезийн байрлал, өндөр, гравиметрийн сүлжээний нарийвчлалыг сайжруулах** | | | | | |
| 1. | Арга хэмжээ 1.1. Хариуцсан чиглэлээр хийх ажлын төсвийн тооцоог гаргах | 60 | 10 | 70 | |
| **Зорилт 2. GNSS-ийн байнгын ажиллагаатай суурин станцын сүлжээг өтгөрүүлэх, техник хангамж болон програм хангамжийн шинэчлэлтийг хийж нэгдсэн удирдлагын системд холбох** | | | | | |
| 1. | Арга хэмжээ 2.1. GNSS-ийн байнгын ажиллагаатай станцын солбицлыг ITRF2020 тогтолцоонд тохируулах | 60 | 10 | 70 | |
| **Зорилт 3. GNSS-ийн байнгын ажиллагаатай суурин станцын хэвийн үйл ажиллагааг хангах** | | | | | |
| 1. | Арга хэмжээ 3.1. GNSS-ийн байнгын ажиллагаатай суурин станцын хэвийн үйл ажиллагааг хангах | 54 | 9 | 63 | |
| 2. | Арга хэмжээ 3.2. GNSS-ийн байнгын ажиллагаатай суурин станцын хяналтын хэмжилт нэгтгэх. | 54 | 9 | 63 | |
| 3. | **Арга хэмжээ 3.3.** GNSS-ийн байнгын ажиллагаатай боловч хэвийн ажиллагаа доголдсон станцын гэмтэлтэй эд ангийг засварлах үйл ажиллагааг зохион байгуулах | 30 | 5 | 35 | |
| **Зорилт 4. GNSS-ийн байнгын ажиллагаатай суурин станц шинээр байгуулах** | | | | | |
| 1. | Арга хэмжээ 4.1. GNSS-ийн байнгын ажиллагаатай суурин станц шинээр байгуулах | | | – | |
| 2. | Арга хэмжээ 4.2. Хуулийн төслийг батлуулахад хамтран ажиллах | | | ? | |
| **Зорилт 5. Геодезийн байрлал, өндөр, гравиметр, GNSS-ийн сүлжээний ITRF2008 солбицлын тогтолцоонд тодорхойлсон цэг тэмдэгтийг ITRF2020 солбицлын тогтолцоонд шилжүүлэх, Геодезийн цэг тэмдэгтийн мэдээллийн санг хөтлөх. Геодезийн байнгын цэг, тэмдэгтийг хадгалах, хамгаалах, тооллого хийх, нөхөн сэргээх ажлыг зохион байгуулах** | | | | | |
| 1. | Арга хэмжээ 5.1. Геодезийн байнгын цэг, тэмдэгтийн цахим санг шинэчлэх | 54 | 9 | 63 | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 2. | Арга хэмжээ 5.2. Геодезийн байнгын цэг, тэмдэгтийг хадгалах, хамгаалах, тооллого хийх, нөхөн сэргээх ажлыг зохион байгуулах | 60 | 10 | 70 | |
| **Зорилт 6. 1:1000-ны масштабтай тоон дэвсгэр зургийг шинээр гүйцэтгэх.** | | | | | |
| 1. | Арга хэмжээ 6.1. Улаанбаатар хотын 1:1000-ны масштабтай байр зүйн зураг зохиох ажил | 60 | 10 | 70 | |
| 2. | Арга хэмжээ 6.2. Өмнөговь аймгийн 4 сумын 1:1000-ны масштабтай байр зүйн зураг зохиох ажлыг шалгаж хүлээн авах | | | — | |
| 3. | Арга хэмжээ 6.3. Бусад байгууллагын захиалгаар хийгдсэн геодези, зураг зүйн ажлыг шалгаж хүлээн авах | 60 | 10 | 70 | |
| **Зорилт 7. Салбарын хууль тогтоомжийн төслийг шинэчлэн боловсруулах, батлуулах, таниулан сурталчлах** | | | | | |
| 1. | Арга хэмжээ 7.1. Шинээр батлагдсан хууль, дүрэм, журам, стандартыг албан хаагчдад мэдээллэх, олон нийтэд сурталчлах, мэдээлэл өгөх ажлыг зохион байгуулах | 60 | 10 | 70 | |
| **Зорилт 8. Статик хэмжилтийн тэгшитгэн бодолтын онлайн боловсруулалтын системийн үйл ажиллагаа** | | | | | |
| 1. | Арга хэмжээ 8.1. Статик хэмжилтийн тэгшитгэн бодолтын онлайн боловсруулалтын системийн хэвийн үйл ажиллагааг хангах | 42 | 7 | 49 | |
| 2. | Арга хэмжээ 8.2. GNSS-ийн байнгын ажиллагаатай суурин станцын нэгдсэн удирдлагын системд шинэ станцын холболтын тоо нэмэгдүүлэх | | | — | |
| 3. | Арга хэмжээ 8.3 Ази-Номхон далайн бүсийн GNSS-ийн станцын хэмжилтийн ажилд оролцох | | | — | |
| 4. | Арга хэмжээ 8.4 ШУА-тай хамтран ООГФХ-ийн GNSS-ийн байнгын ажиллагаатай станцад засвар дамжуулалтыг тохиргоо хийх | 42 | 7 | 49 | |
| 5. | Арга хэмжээ 8.5 Газрын зургийн систем боловсруулах ТЭЗҮ боловсруулахад санал өгч, хамтран ажиллах | | | — | |
| **Зорилт 9. Геодези зураг зүйн цахим үйлчилгээг нэвтрүүлэх** | | | | | |
| 1. | Арга хэмжээ 9.1. Геодези, зураг зүйн цахим систем байгуулах | 60 | 10 | 70 | |
| 2. | Арга хэмжээ 9.2 Геодезийн сүлжээ, цэг, тэмдэгтийн мэдээллийн дэд систем байгуулах | 60 | 10 | 70 | |
| 3. | Арга хэмжээ 9.3 Улсын хилийн тэмдгийн мэдээллийн дэд систем байгуулах | 60 | 10 | 70 | |
| 4. | Арга хэмжээ 9.4 GNSS-ийн өгөгдлийг ITRF2020 тогтолцоонд тэгшитгэн бодох Монпос системийн хөгжүүлэлт хийх | | | — | |
| **Зорилт 10. Монгол Улс, ОХУ хоорондын улсын хил шалгахад зориулан геодези, зураг зүйн ажил хийх** | | | | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 1. | Арга хэмжээ 10.1. Монгол Улс, Оросын Холбооны Улс хоорондын улсын хилийг шалгах Ажлын хэсэгт ажиллах | 60 | 10 | 70 | |
| 2. | Арга хэмжээ 10.2. Монгол Улс, Оросын Холбооны Улс хоорондын улсын хилийг шалгах, зураглах ажлыг зохион байгуулах | 60 | 10 | 70 | |
| 3. | Арга хэмжээ 10.3. Олон улсын зураг зүйн холбоонд геодези, зураг зүйн чиглэлээрх тайлан хүргүүлэхтэй хамтран ажиллах | 54 | 9 | 63 | |
| 4. | Арга хэмжээ 10.4. Шүүх, Авлигатай тэмцэх газар болон эрх бүхий байгууллагаас шинжээчээр томилсон тогтоол, захирамжийн хэрэгжилтийг хангах, дүгнэлт гаргаж хүргүүлэх ажлыг зохион байгуулах | | | — | |
| **Зорилт 11. Геодези, зураг зүйн тухай хуулийн төслийг боловсруулж батлуулах** | | | | | |
| 1. | Арга хэмжээ 11.1 Геодези, зураг зүйн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг холбогдох хурлаар хэлэлцүүлэхэд шаардлагатай баримт мэдээллээр хангах | 60 | 10 | 70 | |
| 2. | Арга хэмжээ 11.2 Геодези, зураг зүйн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг олон нийтэд хэлэлцүүлэх | 60 | 10 | 70 | |
| **Зорилт 12. Салбарын хууль тогтоомж шинэчлэн батлагдахтай холбогдуулан шаардлагатай эрх зүйн бусад актыг шинэчлэн боловсруулах, батлуулах** | | | | | |
| 1. | Арга хэмжээ 12.1. Салбарын хуулиудад нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг боловсруулах, санал өгөх, батлуулах ажлыг зохион байгуулах | | | — | |
| **Зорилт 13. Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ** | | | | | |
| 1. | Арга хэмжээ 13.1. Удирдлагаас болон хурлаас өгөгдсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх, тайлагнах | 60 | 10 | 70 | |
| 2. | Арга хэмжээ 13.2. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд ажиллаж, тайланг тушаалд заасан хугацаанд холбогдох мэргэжилтэнд хүргүүлэх | 60 | 10 | 70 | |
| 3. | Арга хэмжээ 13.3. Тогтоол шийдвэрийн биелэлт гаргах | 60 | 10 | 70 | |
| 4. | Арга хэмжээ 13.4. Хугацаатай албан бичиг, өргөдөл гомдол шийдвэрлэх, хяналт тавьж ажиллах | 60 | 10 | 70 | |
| 5. | Арга хэмжээ 13.5. Албан тушаалтнуудын 2024 оны хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлэг гаргах | 60 | 10 | 70 | |
| 6. | Арга хэмжээ 13.6. Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлуулах, ажлын гүйцэтгэлээ үнэлүүлэх | 60 | 10 | 70 | |
| 7. | Арга хэмжээ 13.7. Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу архивын баримт бүрдүүлэх, хавтаслах, байгууллагын архивт хүлээлгэн өгөх | | | — | |

| Нэмэлт үүрэг даалгаварын биелэлт | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 1. | Үүрэг даалгавар (Арга хэмжээ)<br>1.Улсын хилийн багана тэмдгийн протокол дээрх солбицлыг газар дээр нь тогтоон байршлыг тодорхойлох | 60 | 10 | 70 | |
| 2. | Үүрэг даалгавар (Арга хэмжээ.)<br>2.Орон нутагт хэрэгжүүлэх геодези, зураг зүйн салбарын үйл ажиллагааг сурталчлах, эрчимжүүлэх | 60 | 10 | 70 | |
| 3 | Үүрэг даалгавар (Арга хэмжээ)<br>3.Геодезийн хэлтсийн үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах | 60 | 10 | 70 | |
| 4 | Үүрэг даалгавар (Арга хэмжээ)<br>4.Авлигатай тэмцэх газарт нотлох баримт хүргүүлэх | 60 | 10 | 70 | |
| 5 | Үүрэг даалгавар (Арга хэмжээ) 5. ШУТИС-ын Геологи, Уул уурхайн сургуулийн "ГЕОДЕЗИ 2025" эрдэм шинжилгээний хуралд хамтран ажиллах | 60 | 10 | 70 | |
| 6 | Үүрэг даалгавар (Арга хэмжээ) 6. Байгууллагын эмэгтэйчүүдийн зөвлөлд ажиллах | 60 | 10 | 70 | |
| 7 | Үүрэг даалгавар (Арга хэмжээ) 7. Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд мод тарих арга хэмжээнд оролцох | 60 | 10 | 70 | |
| 8 | Үүрэг даалгавар (Арга хэмжээ) 8. Шинэтгэлээр түүчээлсэн салбар зөвлөл" аяны хүрээнд алба ажил мэргэжлжж сурталчлах | 60 | 10 | 70 | |
| **Дундаж оноо:** | | | | 66.9 | |

## 2. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Арга хэмжээний биелэлтийн хувь | Нийт (15 хүртэл оноогоор) | Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо |
|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 |
| 1. | Арга хэмжээ 1.<br>Байгууллагаас болон төслөөс, олон улсын байгууллагаас зохион байгуулах сургалтад хамрагдах | | 15 | |
| 2. | Арга хэмжээ 2.<br>Төрийн албан хаагчийг мэргэшүүлэх дунд хугацааны давтан сургалтад хамрагдах | | 15 | |
| 3. | Арга хэмжээ 3.<br>Геодезийн Мэргэшсэн инженер болох | | — | |
| 4. | Арга хэмжээ 4.<br>Хууль эрх зүйн мэдлэгээ дээшлүүлэх | | 15 | |
| **Дундаж оноо** | | | 15 | |

## 3. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Нэгжийн даргын үнэлгээ)

| Д/д | Үзүүлэлт | Нэгжийн даргын үнэлгээ (0-7 оноо) | Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо |
|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 |
| 1. | Хандлага, ёс зүй | 6 | |
| 2. | Дүн шинжилгээ хийх | 7 | |
| 3. | Асуудал шийдвэрлэх | 7 | |
| 4. | Хариуцлагатай байдал | 7 | |
| 5. | Ажлын цаг ашиглалт | 6 | |

| Ур чадварын үзүүлэлт (ажлын онцлогоос хамаарсан) | | | |
|---|---|---|---|
| 6. | Мэргэжлийн ур чадвар 1. багаж | 7 | |
| 7. | Мэргэжлийн ур чадвар 2. п/к | 7 | |
| 8. | Мэргэжлийн ур чадвар 3. | | |
| | **Дундаж оноо** | 6.7 | |

**4. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ** (Хамт олны үнэлгээ)

| Д/д | Үзүүлэлт | Хамт олны үнэлгээ (0-8 оноо) |
|---|---|---|
| | 1 | 2 |
| 1. | Хандлага, ёс зүй | 7.7 |
| 2. | Багаар ажиллах | 7.6 |
| 3. | Харилцаа | 7.1 |
| | **Дундаж оноо** | 7.5 |

**5. Гүйцэтгэлийн үнэлгээ**

| Д/д | Үнэлгээний үзүүлэлт | Үзүүлэлт тус бүрийн оноо |
|---|---|---|
| 1. | Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт *(Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт орно.)* | *(70 хүртэлх оноо)* 66.9 |
| 2. | Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт | *(15 хүртэлх оноо)* 15 |
| 3. | Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ *( Нэгжийн даргын үнэлгээ )* | *(7 хүртэлх оноо)* 6.7 |
| 4. | Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ *(Хамт олны үнэлгээ)* | *(8 хүртэлх оноо)* 7.5 |
| 5. | Үнэлгээний оноонд орсон өөрчлөлт *(Аргачлалын 6 дугаар хэсэгт заасан холбогдох заалтыг бичих)* | (-2 оноо) |
| | **Нийт оноо =** ( Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний оноо + Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний оноо + Хандлага, ёс зүй, ур чадварын оноо *(Нэгжийн дарга үнэлгээ)* ) - Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу хассан оноо + Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу нэмсэн оноо | 96.1<br>94.1 |

***Үнэлгээ өгсөн:*** ***Нэгжийн дарга***

ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ХЭЛТСИЙН ДАРГА /Д. Мөнхцэцэг/ Д.МӨНХЦЭЦЭГ

***Үнэлгээтэй танилцаж, зөвшөөрсөн:*** ***Төрийн жинхэнэ албан хаагч:***

БАЙНГЫН АЖИЛЛАГААТАЙ СУУРИН СТАНЦ, БАЙРЛАЛЫН УЛСЫН СҮЛЖЭЭНИЙ АСУУДАЛ ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН /Л. Золзаяа/ Л.ЗОЛЗАЯА

***Үнэлгээг хянасан:***

*Үнэлгээний багийг төлөөлж ахлагч:*

ГЗҮГ-ын дарга ........................ Б. Энхбold

/............................/

*(албан тушаал)* *(гарын үсэг)* *(албан хаагчийн нэр)*

2025.06.17 (огноо)

Үнэлгээний багийн нарийн бичгийн дарга:

ТЗУГ-ын ахлах /мэргэжилтэн/ (албан тушаал) ............ (гарын үсэг) М.Сумъяабазар (албан хаагчийн нэр)

2025.06.17 (огноо)

***Үнэлгээг баталгаажуулсан:  Төсвийн шууд захирагч***

ГАЗРЫН ДАРГА ( ............ ) А.ЭНХМАНЛАЙ

9128321 9024816028

# ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ХЭЛТСИЙН БАЙНГЫН АЖИЛЛАГААТАЙ СУУРИН СТАНЦ, БАЙРЛАЛЫН УЛСЫН СҮЛЖЭЭНИЙ АСУУДАЛ ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН Л.ЗОЛЗАЯАГИЙН 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ТАЙЛАН

## НЭГ. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээ

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэл тийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | |
| **Зорилт 1. Монгол Улсын геодезийн байрлал, өндөр, гравиметрийн сүлжээний нарийвчлалыг сайжруулах** | | | | | | | |
| 1 | **Арга хэмжээ 1.1.** (1.4.1.1) Хариуцсан чиглэлээр хийх ажлын төсвийн тооцоог гаргах | Төсвийн тооцоо-1 | Геодези, зураг зүйн чиглэлээр 2025 онд хийх ажлын төсвийн тооцоог 2024 онд гаргаж СЭЗХ-т хүргүүлсэн. | **Эхний хагас жил** Улсын байрлалын сүлжээ болон GNSS-ийн станцын үйл ажиллагааны чиглэлээр хийх ажлын үндэслэл, хэрэгцээ, шаардлага, төсвийн тооцоо гаргаж, 2026 оны төсөвт тусгуулахаар СЭЗХ-т хүргүүлнэ. | 2026 оны төсвийн төсөлд санал авах үед СЭЗХ-т хүргүүлэхээр "Монгол улсын GNSS-ийн байнгын ажиллагаатай станцын сүлжээг өтгөрүүлэх, байнгын ажиллагааг хангах" ТЭЗҮ-д тусгагдсан болон хэрэгжүүлэх төлөвлөгөөний дагуу 2026 онд шинээр байгуулах БАСС-ын дутмагшилтай байршил, тоног төхөөрөмжийн төсвийн тооцооны зах зээлийн үнийн судалгаа боловсруулж бэлтгэсэн. | 01-03 | 100 |
| **Зорилт 2. GNSS-ийн байнгын ажиллагаатай суурин станцын сүлжээг өтгөрүүлэх, техник хангамж болон програм хангамжийн шинэчлэлтийг хийж нэгдсэн удирдлагын системд холбох** | | | | | | | |
| 1 | **Арга хэмжээ 2.1.** (1.4.3.1) GNSS-ийн байнгын ажиллагаатай станцын солбицлыг ITRF2020 тогтолцоонд тохируулах | Байнгын ажиллагаатай станц-43 | 2022 онд Засгийн газрын 267-р тогтоолоор ITRF2020 солбицлын тогтолцоог баталсан. 2023 онд БАСС 43 станцын өгөгдлийг ITRF2020 солбицлын тогтолцоонд тэгшитгэн бодсон. 2024 онд GNSS-ийн 43 станцын солбицол, хурдны утгыг ITRF2020 солбицлын тогтолцоонд | **Бүтэн жилд:** 1:1000-ны масштабтай байр зүйн болон инженерийн шугам сүлжээний зураглалыг ITRF2020 солбицлын тогтолцоонд зураглах ажлын төсөв батлагдсан аймгийн станцуудын солбицлыг ITRF2020 тогтолцоонд тохируулна. | 2025 онд Дорноговь аймгийн төвийн 1:1000-ны масштабтай байр зүйн болон инженерийн шугам сүлжээний зураглалын ажлыг хийхээр болсон тул байрлалын сүлжээний ажлын үед DOG1 станцыг ITRF2020 тогтолцоонд тохируулсан. | 01-12 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | тэгшитгэн бодож А/289 дугаар тушаалаар батлуулсан. | | | | |
| **Зорилт 3. GNSS-ийн байнгын ажиллагаатай суурин станцын хэвийн үйл ажиллагааг хангах** | | | | | | | |
| 1 | **Арга хэмжээ 3.1.** (1.4.4.1) GNSS-ийн байнгын ажиллагаатай суурин станцын хэвийн үйл ажиллагааг хангах | Байнгын ажиллагаатай суурин станц-48 | 2013-2017 онд Улсын төсвөөр 38, нийслэлийн төсвөөр УБ хотод 5 станц суурилуулсан.<br>2019 онд GNSS-ийн байнгын ажиллагаатай 43 станцын нэгдсэн удирдлагын тогтолцоо бүрдүүлсэн.<br>2024 онд GNSS-ийн байнгын ажиллагаатай 5 станцыг нэгдсэн удирдлагын тогтолцоонд нэмсэн. | **Бүтэн жилд:**<br>GNSS-ийн байнгын ажиллагаатай 48 станцын үйл ажиллагаа тасарсан тухай бүр шалтгааныг тодруулж хэвийн ажиллагааг хангах шаардлагатай арга хэмжээг зохион байгуулсан байна. | Нийслэл болон 21 аймаг орон нутагт суурилуулсан байнгын ажиллагаатай суурин станцуудад (huv2, ub03, hoa1, doa2, boa2, zav1, sua1) үүссэн техникийн болон програм хангамжийн доголдол, интернэт сүлжээ өгөгдөл дамжуулалтын тохиргоог цаг тухай бүрт нь зайнаас хандаж ажиллаж хэвийн ажиллагааг хангасан.<br>2025 оны 02 дугаар сарын 19-ний өдөр Байнгын ажиллагаатай суурин станцын удирдлагын програм хангамж суулгасан виртуал сервер дээр үүссэн үйлдлийн системийн (windows server 16.0 Upgrade) лиценз сунгах асуудлыг МТ хэлтэстэй хамтран зохион байгуулж хэвийн ажиллагаанд оруулсан.<br>2025.04.23-ний өдөр Хэнтий аймгийн 3-н станцын үйл ажиллагаа түр хугацаагаар доголдсон байдлыг хянан шалгаж үзээд удирдлагын програм хангамж дээр холбогдлтын тохиргоо хийж хэвийн ажиллагаанд оруулсан.<br>2025 оны 05 дугаар сарын 28-ний өдөр Хөвсгөл аймгийн Ханх суманд суурилуулсан станцын интернэт сүлжээний доголдлыг аймгийн геодезийн асуудал хариуцсан мэргэжилтэнтэй хамтран зайнаас хандаж ажиллан хэвийн ажиллагаанд оруулсан. | 01-12 | 90 |
| 2 | **Арга хэмжээ 3.2.** (1.4.3.1) GNSS-ийн байнгын ажиллагаатай суурин станцын хяналтын хэмжилт нэгтгэх. | Бодит агшны хяналтын хэмжилт - 48 станц | 21 аймгийн төв, 330 сум, 45 суурингийн төвд геодезийн тулгуур сүлжээний цэг, тэмдэгтийг суурилуулсан. | **Бүтэн жилээр:**<br>GNSS-ийн байнгын ажиллагаатай 48 станцын аймгийн төв, нийслэлд суурилуулсан станцын бодит агшны нарийвчлалыг улиралд 1 удаагийн шалгалтын хэмжилт, сум суурин газрын станцуудад хагас жилд 1 удаагийн шалгалтын хэмжилтийг хүлээн авч нэгтгэнэ. | 2025 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн байдлаар БАСС-ын бодит агшны I улирлын хяналтын хэмжилтийг Улаанбаатар хот, Хөвсгөл, Сүхбаатар, Баян-Өлгий, Сэлэнгэ, Баянхонгор, Булган, Архангай, Өвөрхангай, Говь-Алтай, Дорноговь, Дундговь, Говьсүмбэр, Завхан, Төв, Орхон, Дархан-Уул зэрэг 17 аймаг ирүүлсэн.<br>21 аймгийн ГХБХБГ-ын геодезийн асуудал хариуцсан мэргэжилтэн нарт орон нутагтаа хамаарах станцын хяналтын хэмжилтийг | 01-12 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | цаг хугацаанд нь чанартай хийж гүйцэтгэн талаар зөвлөгөө мэдээлэл хүргэсэн.<br>Увс, Ховд, аймгуудад геодезийн асуудал хариуцсан мэргэжилтэн нь мэргэжлийн бус тус албан тушаалыг хавсран гүйцэтгэж байгаа шалтгааны улмаас ирүүлээгүй.<br>Өмнөговь, Хэнтий аймгууд багажаа шинэчлэх шаардлагатай тул хүлээгдэж байгаа гэсэн тайлбар өгсөн.<br>2025 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн байдлаар БАСС-ын бодит агшны I улирлын хяналтын хэмжилтийг Говь-Алтай, Говьсүмбэр, Хөвсгөл, Сүхбаатар, Баян-Өлгий, Сэлэнгэ, Баянхонгор, Булган, Архангай, Өвөрхангай, Говь-Алтай, Дорноговь, Дундговь, Говьсүмбэр, Завхан, Төв, Орхон, Дархан-Уул зэрэг 18 аймаг ирүүлсэн.<br>Өмнөговь аймаг хэмжилт хийх геодезийн багаж хэрэгсэлгүй гэх шалтгаанаар 2 улирал дараалан хяналтын хэмжилтийг хийж ирүүлээгүй тул 2025 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн 2/1996 дугаар албан бичгээр чиглэл хүргүүлсэн. | | 90 |
| 3 | **Арга хэмжээ 3.3.** (1.4.4.3) GNSS-ийн байнгын ажиллагаатай боловч хэвийн ажиллагаа доголдсон станцын гэмтэлтэй эд ангийг засварлах үйл ажиллагааг зохион байгуулах | Байнгын ажиллагаатай станц-2 | 2023 онд Ховд аймгийн Дарви сумын (HOA2) байнгын ажиллагаатай суурин станцын шатсан эх хавтанг шинэчлэн ажиллагаанд оруулсан.<br>2024 онд Хөвсгөл амйгийн Ханх сумын (HUV2), Сэлэнгэ аймгийн Мандал сумын (SEA2), Хэнтий аймгийн Батширээт сумын (HEA2) станцуудын эх хавтанг шинэчлэн хэвийн үйл ажиллагаанд оруулсан. | **Эхний хагас жилд:**<br>Сүхбаатар аймгийн Дарьганга сумын (SUA2), GNSS-ийн байнгын ажиллагаатай станцын эх хавтанг шинэчлэх ажлыг зохион байгуулсан байна.<br>Ховд аймгийн Дарви сумын (HOA2) байнгын ажиллагаатай суурин станцын үйл ажиллагаа доголдсон шалтгаан гэмтлийг тодорхойлж, засварлах арга хэмжээг зохион байгуулсан байна.<br>**Сүүлийн хагас жилд:**<br>Хэвийн ажиллагаанд орсон 2 станцыг шалган хүлээн авч, хэмжилт зураглалын ажилд ашиглуулсан байна. | Сүхбаатар аймгийн ГХБХБГ-аас (SUA2) станцтай холбоотой зардлыг хэрхэн шийдвэрлэж байгаа талаар асууж тодруулахад аймгийн ИТХ-аар 2025 онд орон нутгийн төсвөөр хэрэгжүүлэх ажлыг төлөвлөгөөнд тусган хэлэлцүүлсэн боловч хасагдсан гэсэн тайлбар өгсөн тул 2025 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн 01/1036 дугаартай албан бичгээр тус ажлыг эрчимжүүлэх чиглэл хүргүүлсэн.<br>Ховд аймгийн ГХБХБГ-т (HOA2) станцын үйл ажиллагааг доголдсны улмаас үүссэн нөхцөл байдал, түүнийг шийдвэрлэхэд тулгамдаж буй асуудалд холбоотой ажил эрчимжүүлэх талаар 2025 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн 1/926 дугаар албан бичиг хүргүүлсэн.<br>Сүхбаатар (SUA2), Ховд (HOA2) аймгийн геодезийн асуудал хариуцсан мэргэжилтэн нарт станцын гэмтлийг засварлах ажилд зохион байгуулах удирдлагыг шаардлагатай мэдээллээр хангах талаар удаа дараа зөвлөгөө чиглэл хүргүүлсэн | 01-12 | 50 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | боловч хариу бичиг, арга хэмжээ авч ажиллаагүй тул 2 аймгийн газрын дарга нартай биечлэн уулзаж ажлыг хэрхэн эрчимжүүлэх талаар ярилцсан. | | |
| **Зорилт 4. GNSS-ийн байнгын ажиллагаатай суурин станц шинээр байгуулах** | | | | | | | |
| 1 | **Арга хэмжээ 4.1.** (1.4.5.1) GNSS-ийн байнгын ажиллагаатай суурин станц шинээр байгуулах | Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан, Ховд аймгийн Булган сумдад Байнгын ажиллагаатай станц-2 | 2024 онд GNSS-ийн байнгын ажиллагаатай 5 станцыг шинээр байгуулж нэгдсэн удирдлагын тогтолцоонд нэмснээр 48 станцтай болсон. | **Эхний хагас жилд:** Шинээр байгуулах байнгын ажиллагаатай суурин станцын ажлын даалгаврыг боловсруулж батлуулах ажлыг зохион байгуулна.<br>**Жилийн эцэст:** Шинээр байгуулсан суурин станцыг шалган хүлээн авч удирдлагын нэгдсэн системд холбоно. | Улсын хилийн дагуу GNSS-ийн Байнгын ажиллагаатай суурин станц суурилуулах, GNSS-ийн хэмжилтийн RTX төхөөрөмж худалдан авах ажлын даалгаврыг боловсруулж Газрын даргаар батлуулахаар нэгжийн дарга нараас санал авч байна.<br>GNSS-ийн RTX төхөөрөмж худалдан авах ажлын холбогдох ТББ бүрдүүлж гүйцэтгэгч нартай гэрээ байгуулах ажлыг зохион байгуулсан.<br>Улсын төсвийн хөрөнгөөр GNSS-ийн байнгын ажиллагаатай 2 суурин станц байгуулах ажлыг төсвийн ерөнхийлөн захирагч түр түдгэлзсэн тул ЗГХЭГ-т зөвшөөрөл авах албан бичгийг хүргүүлсний дараа шийдвэрлэхээр хүлээгдэж байна. | 01-12 | |
| **Зорилт 5. Геодезийн байрлал, өндөр, гравиметр, GNSS-ийн сүлжээний ITRF2008 солбицлын тогтолцоонд тодорхойлсон цэг тэмдэгтийг ITRF2020 солбицлын тогтолцоонд шилжүүлэх, Геодезийн цэг тэмдэгтийн мэдээллийн санг хөтлөх. Геодезийн байнгын цэг, тэмдэгтийг хадгалах, хамгаалах, тооллого хийх, нөхөн сэргээх ажлыг зохион байгуулах** | | | | | | | |
| 1 | **Арга хэмжээ 5.1.** (1.4.6.1) Геодезийн байнгын цэг, тэмдэгтийн цахим санг шинэчлэх | GNSS-ийн дэд болон зураглалын сүлжээний - 100 цэг, тэмдэгт | Геодезийн цэг, тэмдэгтийн мэдээллийн санг шинэчилж, 2022 онд мэдээллийн санг цахимаар түгээх тогтолцоог бүрдүүлсэн. | **Бүтэн жилд:** Бусад байгууллагын захиалгаар хийгдсэн геодезийн ажлын цэг, тэмдэгтийн мэдээллээр геодезийн цахим сангийн шинэчлэлтийг хөтөлнө. Цахим системийн шинэчлэлтэд хяналт тавьж, ирүүлсэн хүсэлтийг баталгаажуулна. | Геопортал цахим системийн эрх үүсгэх, мэдээлэл засварлах үйл ажиллагаанд доголдол үүссэн ба геодезийн цэг тэмдэгтийн хүсэлт ирээгүй.<br>Үүнтэй холбоотой системд геодезийн цэг тэмдэгт Геопортал системд оруулах, гаргах, хянах үед үүсч буй алдааг МТХ-ээс тодруулахаар хүсэлт гаргасан.<br>ОЗӨДБГ-аас Геопортал цахим системийн хөгжүүлэлтийн ажлыг хийгдэж байгаатай холбоотой геодезийн цэг тэмдэгтийн мэдээллийн дэд санд шинэчлэлт хийх боломжгүй хүлээгдэж байна. | 01-12 | 90 |
| 2 | **Арга хэмжээ 5.2.** (1.4.6.2) Геодезийн байнгын цэг, тэмдэгтийг | GNSS-ийн дэд болон зураглалын сүлжээн | 2019 онд Газрын даргын А/291 дугаар тушаалаар "Геодезийн байнгын | **Бүтэн жилд:** Нөхөн сэргээсэн цэг тэмдэгтийн хүсэлт ирүүлсэн тухай бүрд хүлээн авч, цахим санд оруулна. | Говьсүмбэр аймгийн ГХБХБГ-ын Сүмбэр сумын орон нутгийн хөгжлийн сангийн төсвөөр устсан 12 геодезийн байнгын цэг тэмдэгтийг нөхөн сэргээх, шинээр | 01-12 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хадгалах, хамгаалах, тооллого хийх, нөхөн сэргээх ажлыг зохион байгуулах | ий цэг, тэмдэгт | цэг, тэмдэгтийг хадгалах, хамгаалах, нүүлгэн шилжүүлэх" журмыг баталсан. | Нөхөн сэргээсэн цэг тэмдэгтийн хүсэлт ирүүлсэн тухай бүрд хүлээн авч, цахим санд оруулна. 21 аймаг, нийслэлийн геодезийн байнгын цэг, тэмдэгтийн тооллогын мэдээллийг цахим санд оруулсан үр дүнд хяналт тавьж, баталгаажуулна. | суулгахаар ирүүлсэн ажлын даалгаврын төслийг хянаж сайжруулан АД/2025-26 дугаар бүхий Ажлын даалгаврыг ГЗБГЗЗЕГ-ын даргаар батлуулан 2025 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн 1/551 дугаар албан бичгээр хүргүүлсэн.<br>Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын геодезийн байнгын цэг тэмдэгтийг нөхөн сэргээх, шинээр суулгахаар ажлын тайланг хүлээн авч 2025 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн ГЗЗХ-2025/06 дугаар дүгнэлтээр ГЗЗХ-2025/01 дугаартай дүгнэлтээр Геодези, зураг зүйн мэдээллийн улсын нэгдсэн санд хүлээлгэн өгөв. | | 100 |
| **Зорилт 6. 1:1000-ны масштабтай тоон дэвсгэр зургийг шинээр гүйцэтгэх.** | | | | | | | |
| 1 | **Арга хэмжээ 6.1.** (1.5.1.1) Улаанбаатар хотын 1:1000-ны масштабтай байр зүйн зураг зохиох ажил | 1 хотын төвийн зураглал | 21 аймаг, 330 сум, 45 суурин газарт зохиогдсон 1:1000-ны масштабтай байр зүйн зургийг 2013-2017 онд зурагласан. | **Эхний хагас жилд:**<br>Улаанбаатар хотын 1:1000-ны масштабтай байр зүйн зураг зохиох ажлын байрлалын сүлжээг шалгаж Геодези, зураг зүйн мэдээллийн нэгдсэн санд хүлээлгэн өгнө. | "Нийслэлийн нутаг дэвсгэрт 1:1000-ны масштабтай байр зүйн зураг зохиох" ажлын дундын тайланд тусгагдсан геодезийн сүлжээ байгуулах ажлыг шалгаж холбогдох дүгнэлтийг бичсэн.<br>Тус ажлын гүйцэтгэгчээс "Нийслэлийн нутаг дэвсгэрт 1:1000-ны масштабтай байр зүйн зураг зохиох" ажлын дундын тайланг хүлээн авч дүгнэлт, байрлалын сүлжээ, цэг тэмдэгт байгуулах чиглэлийн ажлуудад тайланг тусгах засварлах шаардлагатай мэдээллийг 2025 оны 04 дүгээр сарын 16-ны өдөр албаны цахим шуудангаар хүргүүлсэн.<br>Захиалагчийн хяналтын тайланд холбогдох мэдээллийг нэмж оруулан, дундын тайланг ГЗЗХ/2025/02 дугаартай дүгнэлтээр Геодези, зураг зүйн улсын нэгдсэн санд хүлээлгэн өгөв. | 01-12 | 100 |
| 2 | **Арга хэмжээ 6.2.** (1.5.1.3) Өмнөговь аймгийн 4 сумын 1:1000-ны масштабтай байр зүйн зураг зохиох ажлыг шалгаж хүлээн авах | 1 сумын зураглалын ажлын даалгавар, зураглал | 2024 онд геодезийн сүлжээг байгуулж агаараас газрын зураг авсан. | **Эхний хагас жилд:**<br>Өмнөговь аймгийн Даланзадгад, Ханбогд, Гурвантэс, Цогтцэций сумын 1:1000-ны масштабтай байр зүйн зураг зохиох ажлын байрлалын сүлжээг шалгаж Геодези, зураг зүйн мэдээллийн нэгдсэн санд хүлээлгэн өгнө. | Өмнөговь аймгийн Даланзадгад, Ханбогд, Гурвантэс, Цогтцэций сумын 1:1000-ны масштабтай байр зүйн зураг зохиох ажлын сүлжээг шалгах ажлын тайланг ирүүлээгүй болно. | 01-12 | — |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3 | **Арга хэмжээ 6.3** (2.6.1.2) Бусад байгууллагын захиалгаар хийгдсэн геодези, зураг зүйн ажлыг шалгаж хүлээн авах | Геодези, зураг зүйн ажлын үр дүн ирүүлсэн хүсэлтийн тоогоор | 2024 онд ААН-ийн ирүүлсэн хүсэлтэд хяналт хийж, дүгнэлтээр Геодези, зураг зүйн улсын нэгдсэн санд хүлээлгэн өгсөн. | **Бүтэн жилд:** Хүсэлт ирсэн тухай бүрд ажлыг шалгаж, үр дүнг Геодези, зураг зүйн улсын нэгдсэн санд хүлээлгэн өгсөн байна. | “Геосет” ХХК-ийн Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын Геодезийн байнгын цэг тэмдэгтийн хайгуул судалгаа, суулгалт, GNSS-ийн сүлжээний хэмжилт, бодолтын ажлын тайланг шалгаж 2025 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн ГЗЗХ/2025/06 дугаартай дүгнэлт гаргав.<br>“Барилгын хөгжлийн төв” ТӨҮГ болон “Геомастер” ХХК-уудын хооронд байгуулсан 2024 оны 11 дүгээр сарын 07-ны өдөр байгуулсан 2024/173 дугаартай гэрээний дагуу хийгдсэн Ховд аймгийн Дарви сумын 1:1000-ны масштабтай байр зүйн зураглалын ажлын тайлангийн байрлалын сүлжээнийажлыг шалгаж, тайланг засварлаж зайлшгүй шаардлагатай мэдээлэл, зөвлөгөө чиглэлийг холбогдох норм дүрмийн дагуу хангуулж ирүүлэх талаар 2025 оны 06 дугаар сарын 04-ний өдрийн 2/2006 албан бичгээр мэдэгдсэн. | 01-12 | 100 |
| **Зорилт 7. Салбарын хууль тогтоомжийн төслийг шинэчлэн боловсруулах, батлуулах, таниулан сурталчлах** | | | | | | | |
| 1 | **Арга хэмжээ 7.1.** (2.4.1.1) Шинээр батлагдсан хууль, дүрэм, журам, стандартыг албан хаагчдад мэдээллэх, олон нийтэд сурталчлах, мэдээлэл өгөх ажлыг зохион байгуулах | Сургалтын тоо<br>Хамрагдсан иргэн, хуулийн этгээдийн тоо | Хуулийн төслүүд болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хамт УИХ-аар хэлэлцүүлэхээр дэмжсэн. | **Бүтэн жилд:** Газрын харилцааны салбарт шинээр болон шинэчлэн батлагдсан эрх зүйн баримт бичгийг салбарын мэргэжилтнүүд, аж ахуйн нэгжүүдэд мэдээлэх, танилцуулах сургалтыг зохион байгуулсан байна. | Газрын тухай хууль болон салбарын үйл ажиллагаа, тэдгээрийн харилцааг зохицуулж буй зарим эрхзүйн баримт бичиг, дүрэм журам, цахим системийн үйл ажиллагаа зэргийг багцлан Удирдлагын академийн дунд хугацааны давтан сургалтын сонсогч нарт бие даалтын цаг дээр 2025 оны 03 дугаар сарын 11-нд танилцуулсан.<br>Төрийн албаны зөвлөлийн даргын 2025 оны 15 дугаар тушаалаар батлагдсан “ШИНЭТГЭЛЭЭР ТҮҮЧЭЭЛСЭН САЛБАР ЗӨВЛӨЛ” аяны хүрээнд Төрийн албаны зөвлөлийн Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын дэргэдэх салбар зөвлөлөөс баталсан төлөвлөгөөний дагуу “Төрийн албаны нөөцөд байгаа иргэн болон их дээд сургуульд суралцаж буй оюутан, ерөнхий боловсролын сургуулийн төгсөх ангийн сурагчдад Монголын төрт ёсны түүхэн уламжлал, төрийн албаны онцлог, бахархал, төрийн албанд ажиллахын давуу талыг сурталчлах арга хэмжээг зохион байгуулах” ажлын хүрээнд 2025 оны 05 дугаар сарын 01-ний өдөр Шинжлэх ухаан, | 01-12 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | технологийн их сургуулийн Геодези мэргэжлээр суралцаж буй 2-4 дүгээр курсын 30 гаруй оюутнуудад төрийн албаны онцлог, бахархал, төрийн албанд ажиллахын давуу талыг сурталчлан танилцуулсан. | | |
| **Зорилт 8. Статик хэмжилтийн тэгшитгэн бодолтын онлайн боловсруулалтын системийн үйл ажиллагаа** | | | | | | | |
| 1 | **Арга хэмжээ 8.1.** (2.6.2.1) Статик хэмжилтийн тэгшитгэн бодолтын онлайн боловсруулалтын системийн хэвийн үйл ажиллагааг хангах | Систем-1 | GNSS-ийн байнгын ажиллагаатай станцын сүлжээнд тулгуурлан статик хэмжилтийн тэгшитгэн бодолт хийдэг онлайн боловсруулалтын системийг 2019 онд хөгжүүлж, хэрэглээнд нэвтрүүлсэн.<br>2022 онд GNSS-ийн онлайн тэгшитгэн бодолтын MONPOS цахим системд нэмэлт хөгжүүлэлт хийсэн. | **Бүтэн жилд:**<br>MONPOS онлайн боловсруулалтын системийн тэгшитгэн бодолтын хэвийн үйл ажиллагааг хангана.<br>MONPOS онлайн боловсруулалтын систем дэх GNSS-ийн байнгын ажиллалаатай суурин станцуудын урт хугацааны өгөгдөл, засвар дамжуулалтын хэвийн үйл ажиллагааг хангана. | 2025 оны 02 дугаар сарын 19-ний өдөр байнгын ажиллагаатай суурин станцын удирдлагын болон өгөгдөл бүрдүүлэлтийн виртуал сервер дээр windows үйлдлийн системийн лицензийн эрхтэй холбоотой асуудал гарч БАСС-ууд болон MonPOS системийн үйл ажиллагаа доголдсон.<br>Үүссэн нөхцөл байдалтай холбогдуулан БАСС-ын засвар дамжуулалт болон статик хэмжилтийн тэгшитгэн бодолтын онлайн боловсруулалтын MONPOS систем ашиглагч иргэд, аж ахуй нэгжүүдэд цаг үеийн мэдээ бэлтгэн байгууллагын нүүр хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээллэсэн.<br>Тус асуудлыг Мэдээлэл технологийн хэлтэстэй хамтран ажиллаж 2025 оны 02 дугаар сарын 20-ны өдөр хэвийн ажиллагаанд оруулсан.<br>Баян-Өлгий аймгийн аймгийн байнгын ажиллагаатай (BOA2) станцын статик өгөгдөл Монпос системд илгээгдээгүй байсныг 2025 оны 03 дугаар сарын 20-ны өдөр аймгийн геодезийн асуудал хариуцсан мэргэжилтэн болон Ногооннуур сумын даамал нартай зайнаас холбогдож хамтран ажиллаж Монпос системийн серверт автоматаар өгөгдөл илгээх FTP тохиргоог хийсэн.<br>GNSS-ийн байнгын ажиллагаатай суурин станцыг ашиглан хэмжилт зураглалын ажил хийж буй иргэн, хуулийн этгээд, хэрэглэгчийн дуудлага, түгээмэл асуултад хариу өгч 66.181.168.80 хаягаар хэрхэн нэвтэрч орж станцтай холбогдох зөвлөгөө мэдээллийг тогтмол өгч ажилласан.<br>Геосет ХХК, Баясах Сүрвэй ХХК-ний хүсэлтээр GNSS-ийн хэмжилтийн өгөгдлийг MonPOS цахим систем ашинлан ITRF2020 солбицлын тогтолцоонд тэгшитгэн | 01-12 | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | бодохдоо тус компаниудын хэмжилтийн багажны Олон улсын GNSS-ийн IGS-д шинээр бүртгэлтэй антен хүлээн авагчийн нэр, дугаарыг Мэдээлэл технологийн хэлтсийн системийн хөгжүүлэлт хариуцсан инженерт хандаж нөхцөл шалгах файлд нэмж оруулсан. | | |
| 2 | **Арга хэмжээ 8.2.** (2.6.2.2) GNSS-ийн байнгын ажиллагаатай суурин станцын нэгдсэн удирдлагын системд шинэ станцын холболтын тоо нэмэгдүүлэх | 5 станц | 2019 онд GNSS-ийн байнгын ажиллагаатай 43 станцын нэгдсэн удирдлагын тогтолцоо бүрдүүлсэн.<br>2024 онд шинээр байгуулсан 5 станц нэмж нэгтгэснээр байнгын ажилалаагаатай 48 станцыг удирдлагын нэгдсэн системд холбосон. | **Эхний хагас жилд:** Одоо ашиглаж буй удирдлагын системд (SNIP-NTRIP) шинээр байгуулах станцын холбоход шаардлагатай лицензийн тоог нэмэгдүүлэх төсвийн тооцоог гаргаж СЭЗХ-т хүргүүлэх<br><br>**Сүүлийн хагас жилд:** Шинээр байгуулсан станцыг нэгдсэн удирдлагын системд холбох ажлыг зохион байгуулна. | GNSS-ийн байнгын ажиллагаатй суурин станцын удирдлагын программ дээр лицензийн тоог нэмэгдүүлэх урсгал төсвийн тооцоог СЭЗХ-т хүргүүлсэн боловч 2025 онд GNSS-ийн байнгын ажиллагаатай суурин станцыг улсын төсвийн хөрөнгөөр шинээр байгуулах ажлын төсөв хасагдсан тул одоогоор нэгдсэн удирдлагын системд шинэ станц холбох хэрэгцээ шаардлага үүсээгүй байна. | 06-12 | – |
| 2 | **Арга хэмжээ 8.3** (2.6.2.3) Ази-Номхон далайн бүсийн GNSS-ийн станцын хэмжилтийн ажилд оролцох | Ази-Номхон далайн бүсийн геодезийн сүлжээний 6 станц | 2024 онд 6 цэгийн хэмжилтийн мэдээллийг Ази-Номхон далайн бүсийн геодезийн группт илгээсэн. | **Сүүлийн хагас жилд:**<br>Ази-Номхон далайн бүсийн геодезийн ажлын группээс ирүүлсэн мэдэгдлийн дагуу Монгол Улсын 6 GNSS-ийн байнгын ажиллагаатай станцын хэмжилтийн өгөгдлийг бэлтгэн илгээнэ. | Хугацаа болоогүй. | 09-12 | – |
| 3 | **Арга хэмжээ 8.4** (2.6.2.4) ШУА-тай хамтран ООГФХ-ийн GNSS-ийн байнгын ажиллагаатай станцад засвар дамжуулалтыг тохиргоо хийх | 1 станц | ШУА-ийн ГФООХ-тэй хамтран ажиллах гэрээг 2023 оны 08 дугаар сарын 31-нд байгуулсан. | **Сүүлийн хагас жилд:**<br>Хамтын ажиллагааны гэрээний хүрээнд ООГФХ-ийн Хөвсгөл аймгийн Хатгал сумын станцыг байгууллагын нэгдсэн сүлжээнд холбож тухайн байршилд бодит агшны засвар дамжуулалтаар (RTK) хангана. | ШУА-ийн ГФООХ-ийн хариуцан ажиллуулдаг Хөвсгөл аймгийн Хатгал суманд суурилуулсан GNSS-ийн байнгын ажиллагаатай (htgg) станцыг тухайн сум суурин газарт геодезийн хэмжилт зураглалын RTK бодит агшны засвар дамжуулалтад ашиглахаар холбогдох албан хаагчидтай 2025 оны 04 дүгээр сарын 09-ний өдөр уулзаж зайнаас хандан хамтран ажилласан боловч хоёр байгууллагын дотоод сүлжээний тохиргоог өөрчилж шинэчлэх шаардлага үүссэн тул мэдээлэл технологийн хэлтэстэй | 06-10 | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | зөвшилцөж шийдэл гаргахаар ажиллаж байна. | | |
| 4 | **Арга хэмжээ 8.5** (2.6.2.5) Газрын зургийн систем боловсруулах ТЭЗҮ боловсруулахад санал өгч, хамтран ажиллах | ТЭЗҮ-1 | Геодези, зураг зүйн удирдлагын нэгдсэн системтэй болсон. Геодезийн хэмжилт, зураглалын багаж баталгаажуулалтын дэд систем хийсэн. | **Эхний хагас жилд:** Газрын зургийн систем хөгжүүлэх Техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах Ажлын даалгаварт санал өгсөн байна. **Жилийн эцэст:** Геодези, зураг зүйн системийг хөгжүүлэх Техник, эдийн засгийн үндэслэлийг холбогдох хурлаар хэлэлцүүлэх, батлуулах ажлыг зохион байгуулахад хамтран ажилласан байна. | Геодези, зураг зүйн системийг хөгжүүлэх Техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах Ажлын даалгаварт санал өгөв. | 01-12 | — |
| **Зорилт 9. Геодези зураг зүйн цахим үйлчилгээг нэвтрүүлэх** | | | | | | | |
